



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 СУУРЬ БОЛОВСРОЛ

9
АНГИ

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:

САНАМЖ


- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: СОНГОХ ДААЛГАВАР

- Мэдээллийн нийгмийн сөрөг талыг сонгоно уу.
 - Мэдээллийг цаг хугацаа, орон зайнаас үл хамааран солилцох
 - Байгууллагууд МХХТ-ийн тусламжтай иргэд, аж ахуй нэгжтэй хамтран ажиллах
 - Зохиогчийн эрх, оюуны өмчийн хулгай ихээр гарах
 - Ажилчид гэрээсээ ажлаа хийх боломж бүрдсэн нь ажлын хүртээмжид нөлөөлсөн
- Мэдээллийн аюулгүй байдлыг хангах өгүүлбэрүүдийн үнэн (Y), худлыг (X) тодорхойлно уу.
 - Фэйсбүүкийн нууц үгээ төрсөн он, сар, өдрөөр хийх нь найдвартай
 - Цахим шуудангаар ирсэн файлын вирусийг байнга шалгаж байх
 - Хувийн зураг, бичлэгээ сошиалд оруулах нь хадгалах хамгийн зөв арга
 - Миний гар утас зөвхөн хурууны хээгээр түгжээ нь тайлагддаг. Энэ нь мэдээллийн логик хамгаалалт юм.
 - Бат миний найз тул би түүний сошиалд оруулсан мэдээллийг олон нийтэд тарааж болно.
 - 1-X, 2-X, 3-Y, 4-X, 5-Y
 - 1-X, 2-Y, 3-X, 4-Y, 5-X
 - 1-Y, 2-Y, 3-X, 4-X, 5-X
 - 1-Y, 2-X, 3-Y, 4-Y, 5-Y
- Сурагч С-д 2 м хөнгөн цагаан байв. Хөнгөн цагааны температурыг 10°C-ээс 30°C хүртэл халаахад тэлдэг. В6 нүдэнд шугаман тэлэлтийг ямар томъёогоор олох вэ?


	А	В
1	Хэмжигдэхүүн	Утга
2	Анхны урт l_0	2
3	Анхны температур t_1^0	10
4	Эцсийн температур t_2^0	30
5	Хөнгөн цагааны шугаман тэлэлтийн коэффициент α	0.024
6	Шугаман тэлэлт Δl	
7		
8	Ашиглах томъёо	$\Delta l = \alpha \cdot l_0 \cdot (t_2^0 - t_1^0)$
9		

- $=B2 \cdot B5 \cdot (B3 - B4)$
 - $=B5 \cdot B2 \cdot (B3 - B4)$
 - $=B5 \cdot B2 \cdot (B4 - B3)$
 - $=B4 \cdot B3 \cdot (B5 - B2)$
- Зурагт сүлжээний ямар зохион байгуулалтыг ашигласан бэ?



- Од (star)
- Гол шугамт (bus)
- Гол шугамт ба од (bus & star)
- Цагариг ба од (ring & star)

5. Багш ангийн 15 компьютерыг холбож, сурагчид дотоод сүлжээгээр өгөгдөл дамжуулах, мөн хэвлэгчийг хүүхэд бүр ашиглах боломжоор хангахаар шийджээ. Сүлжээний аюулгүй байдлын үүднээс интернэтэд холбох шаардлагагүй. Түүнд шаардлагатай дотоод сүлжээний төхөөрөмжүүдийг сонгоно уу.


				
1. Шилэн кабель	2. UTP кабель	3. Свич	4. RJ 45 шилэн толгой	5. Хэвлэгч

- A. 1, 2, 3 B. 2, 3, 4 C. 3, 4, 5 D. 2, 4, 5
6. Программ хангамжийн эх код нь нийтэд ил, үзэх, судлах, үнэлэх, дүгнэх, шинэчлэн өөрчлөх боломж бүгдэд адил тэгш байдаг программ хангамжийг сонгоно уу.
- A. Нээлттэй эхийн (Open Source)
B. Арилжааны (Commercial software)
C. Дундын (Shareware)
D. Чөлөөт (Freeware)
7. Зөв харгалзуулна уу.


1. Арилжааны программ хангамж
2. Чөлөөт программ хангамж
3. Нээлттэй эхийн программ хангамж



- A. 1b, 2a, 3c
B. 1a, 2c, 3b
C. 1c, 2a, 3b
D. 1b, 2c, 3a
8. Сурагч Б талбай олох томъёог блок схемээр дүрслэхээр болов. $a=27$, $b=15$ ($s=27 \times 15$) бол утга олгох блок схемийг сонгоно уу.




9. Дараах алгоритм нь юу хийх вэ? Зөв хариултыг сонгоно уу.



- A. 1-ээс n хүртэлх тооны үржвэрийг олох
- B. 1-ээс n хүртэлх тооны нийлбэрийг олох
- C. i тоог нэгээр нэмэгдүүлэх
- D. s болон i тоонуудыг үржүүлэх

10. Дараах блок схемд $n = 4$ үед алгоритмын үр дүнг тооцоолж, гарах үр дүнг сонгоно уу.



- A. 30
- B. 10
- C. 15
- D. 55

11. Автомат гарчиг, хөл толгойн мэдээлэл, зүүлт тайлбар зэрэг төрөл бүрийн мэдээлэл боловсруулах боломжтой программыг сонгоно уу.



A. Word



B. Excel




C. PowerPoint




D. OneNote

12. Баримт бичиг боловсруулах программд дараах бичвэрийг $a_n = a_1 + d(n - 1)$ ямар командаар оруулах вэ?




A.



B.




C.



D.

13. Командуудыг тайлбартай нь зөв харгалзуулна уу.



a. Нүүр хуудас үүсгэх



b. Тусгай тэмдэгт, томъёо оруулах



c. Зүүлт, тайлбар оруулах



d. Хөл толгойн мэдээлэл оруулах

- A. 1b, 2c, 3d, 4a
- B. 1d, 2a, 3b, 4c
- C. 1b, 2a, 3d, 4c
- D. 1d, 2b, 3c, 4a

14. Сурагч Э баримт бичиг боловсруулах программ дээр дараах хуудсыг бэлтгэжээ. Түүний ашигласан командуудыг сонгоно уу.

Мэдээллийн технологи-9	
ГАРЧИГ	
МХХТ-ИЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТ	2
1.1. Мэдээллэн загвар	2
1.1.1.Мэдээллийн нийгэм түүний давуу тал	2
1.1.1.Мэдээллийн нийгмийн гүйцэтгэх үүрэг	4
1.1.2.Мэдээллийн нийгэмд шилжих үйл явц	4
1.1.3.Мэдээллийн нийгмийн ирээдүй	6
1	

- A. Footer, Insert Footnote, Header, Heading 1, Heading 2, Heading 3, Heading 4
- B. Page Number, Header, Table of Contents, Heading 1, Heading 2, Heading 3
- C. Page Number, Footer, Table of Contents, Heading 1, Heading 2
- D. Footer, Page Number, Header, Heading 1, Heading 2, Heading 3, Heading 4


15. Paint.NET программ нь график ашиглан зургийг цэгэн дүрслэлээр бүтээдэг.

- A. растер
- B. цэгэн
- C. геометр
- D. вектор

16. Гар утас нь ямар шинж чанартай зураг үүсгэх вэ?

- A. Өнгө нягтралын гажуудалгүй растер зураг үүсгэнэ.
- B. Зургийн хэмжээг ихэсгэхэд өнгө, нягтрал нь сарнидаг вектор зураг үүсгэнэ.
- C. Зургийн хэмжээг ихэсгэхэд өнгө, нягтрал нь сарнидаг растер зураг үүсгэнэ.
- D. Өнгө нягтралын гажуудалгүй вектор зураг үүсгэнэ.



17. Paint.NET программд дараах зургийн дэвсгэрийг устгаж хадгалжээ. Дараах алхмуудад ашигласан командыг сонгоно уу.





- A. Move Selection хэрэгслээр идэвхжүүлээд Delete товчлуураар дэвсгэр өнгө устгана.
- B. Rectangle Select хэрэгслээр идэвхжүүлээд Enter товчлуураар дэвсгэр өнгө устгана.
- C. Magic Wand хэрэгслээр идэвхжүүлээд Delete товчлуураар дэвсгэр өнгө устгана.
- D. Ellipse Select хэрэгслээр идэвхжүүлээд Delete товчлуураар дэвсгэр өнгө устгана.

18. Сурагч М Paint.NET программ дээр “Сагсан бөмбөг”-ийн тэмцээний 3000x2000 ppi харьцаатай постер зураг бэлтгэхээр болов. Түүний шинээр нээх файлын тохиргоо болон 3000x2000 нь хэдэн ширхэг пикселээр дүрслэгдэхийг сонгоно уу.

- A. 5.150 ширхэг пикселийг дүрсэлнэ.
- B. 6.000.000 ширхэг пикселийг дүрсэлнэ.



- C. 5.000 ширхэг пикселийг дүрсэлнэ.
- D. 6.000.000 ширхэг пикселийг дүрсэлнэ.



19. MS Excel программ дээр томъёог зөв оруулсан хэсгийг сонгоно уу.

- A. =B4+C4
- B. B4-D4
- C. =4C*5F
- D. 4G/6R

20. Дараах хүснэгтийн өгөгдлийг ажиглаад B1, D2, D3 нүднүүдэд оруулсан томъёог зөв харгалзуулна уу.

	A	B	C	D
1	-1	сөрөг		
2	2	ээрэг	ээрэг	5
3	-3	сөрөг	сөрөг	3
4	4	ээрэг		
5	7	ээрэг		
6	4	ээрэг		
7	-9	сөрөг		
8	5	ээрэг		

- 1. B1 a. =COUNTIF(B1:B8,"ээрэг")
- 2. D2 b. =IF(A1>0,"ээрэг","сөрөг")
- 3. D3 c. =COUNTIF(B1:B8,"сөрөг")

- A. 1c, 2b, 3a
- B. 1a, 2b, 3c
- C. 1b, 2c, 3a
- D. 1b, 2a, 3c

САНАМЖ

- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултыг сонгож, харгалзах үсгийн дагуу хариу бөглөнө. Жишээлбэл: [а] даалгаврын 4 дэх нь зөв хариу гэж үзвэл [а] мөрний 4 гэсэн нүдийг харандаагаар будна.

ХОЁРДУГААР ХЭСЭГ: ЗАДГАЙ ДААЛГАВАР

2.1

	A	B	C	D
1	Миний хуримтлал			
2	Сар	Орлого	Үлдэгдэл	Хүү %
3				1.58
4	1	₮50,000.00	₮50,000.00	₮791.67
5	2	₮10,000.00	₮60,791.67	₮962.53
6	3	₮8,000.00	₮69,754.20	₮1,104.44
7	4	₮5,000.00	₮75,858.64	₮1,201.10
8	5	₮5,000.00	₮82,059.74	₮1,299.28
9	6	₮15,000.00	₮98,359.02	₮1,557.35
10	7	₮20,000.00	₮119,916.37	₮1,898.68
11	8	₮30,000.00	₮151,815.04	₮2,403.74
12	9	₮33,000.00	₮187,218.78	₮2,964.30
13	10	₮16,000.00	₮206,183.08	₮3,264.57
14	11	₮11,000.00	₮220,447.65	₮3,490.42
15	12	₮21,000.00	₮244,938.07	₮3,878.19
16		₮224,000.00	₮248,816.25	₮24,816.25

Сурагч Н хугацаатай хадгаламж нээлгэв. Сар бүр тодорхой хэмжээний орлого нэмж, 1 жилийн хугацаанд хэдэн төгрөгтэй болох вэ? гэдгийг урьдчилан мэдэх зорилгоор дээрх хүснэгтийг боловсруулах шаардлагатай болов. Сурагч Н-д зориулан дараах асуудлуудыг шийдвэрлэхэд нь туслаарай.

- A. Жилийн 19%-ийн хүүтэй хадгаламж байвал сард хэдэн хувийн хүүтэйг тооцох тооцооллыг D3 нүдэнд оруулав. Аль тооцоолол зөв бэ?
1. $=19/12*100$
 2. $=19/12$
 3. $=19/100*12$
 4. $D3=19/12$
 5. $D3=1.58$
- B. C5 нүдэнд 2 дугаар сарын үлдэгдлийг тооцож байгаа бол аль тооцоолол зөв бэ?
1. $=B+C+D$
 2. $=5+4+4$
 3. $=B4+C4+D4$
 4. $=B5+C5+D5$
 5. $=B5+C4+D4$
- C. 12 дугаар сард хэдэн төгрөгийн хүү олгогдож байгаа тооцооллыг ($=C15/100*D$3$) аль нүдэнд оруулах вэ?
1. D15
 2. C15
 3. B15
 4. \$D\$3
 5. C14
- D. Нэг жилийн хугацаанд нийт хэдэн төгрөгийн хүү цуглуулсныг D16 нүдэнд тооцоолол хийв. Аль тооцоолол зөв бэ?
1. $=AVERAGE(D4:D15)$
 2. $=IF(D4:D15)$
 3. $=SUM(D4:D15)$
 4. $=(D4:D15)$
 5. $=COUNTIF(D4:D15)$
- E. C16 нүдэнд нэг жилийн хугацаанд нийт хэдэн төгрөгтэй болж байгаа тооцооллыг олон аргаар оруулах боломжтой бол дараах тооцооллын алийг нь ашиглах **БОЛОМЖГҮЙ** тооцоолол вэ?
1. $=C15+D15$
 2. $=B16+D16$
 3. $=SUM(C15,D15)$
 4. $=SUM(B4:D15)$
 5. $=SUM(B4:B15)+SUM(D4:D15)$